

“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-ЫН  
ЗАХИРАЛ Д.ТОГТОХСҮРЭН ТАНАА

ХАБХ АЛТАСТ

Завьяагоров.



Тендерийн хүчинтэй хугацаа  
сунгуулах тухай

2024.10.15

Монголпросцветмет ТӨҮГ-ын захирлын А/187 тоот тушаалын дагуу “Вандан кран” нийлүүлэх тендерийн захиалагчийн шийдвэрт тус тендерт оролцсон Вира сервис ХХК-с Сангийн яамд гомдол гарсантай холбоотой тендерийг хянан үзээд ТБОНӨХБАҮХАТХуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн тендер шалгаруулалтын хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдсэн тул мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалтыг үндэслэн тендерийн хүчинтэй хугацааг ажлын 15 хоногоор сунгаж өгнө үү.

Хянасан:

Үнэлгээний хорооны дарга



Л.Хүрэлхишиг

Боловсруулсан:

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга



С.Одончимэг




“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН  
ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.10.07 № 03/8289  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАБХалтас

  
2024.10.10

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МРЦМ/20240102306 дугаартай “Вандан кран” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Вира сервис” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу оролцогчоос ирүүлсэн гомдлын хүрээнд хянан үзлээ.

“Вира сервис” ХХК-ийн гомдолд тус тендерт шалгарсан “Моксан” ХХК нь хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл ирүүлэхдээ “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/202301869 дугаартай “Өргөн тээвэрлэх тоног төхөөрөмж” нийлүүлэх тендер шалгаруулалтад 2024 оны 04 дүгээр сарын 18-нд шалгарч гэрээ байгуулах эрх авсан боловч энэ тухай мэдээллийг ирүүлээгүй нь шаардлага хангахгүй байх тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Моксан” ХХК-ийн тендерийн материалыг гомдолд дурдсан үндэслэлийн дагуу хянан үзлээ.

Худалдан авах ажиллагааны цахим системээс ЭҮТӨҮГ/202301869 дугаартай “Өргөн тээвэрлэх тоног төхөөрөмж” нийлүүлэх тендер шалгаруулалтын үр дүнг үзэхэд “Моксан” ХХК шалгарч 2024 оны 04 дүгээр сарын 18-нд гэрээ байгуулах эрх олгосон байна.

Харин “Моксан” ХХК-ийн тендерийг хянан үзэхэд гүйцэтгэсэн гэрээт ажлын жагсаалтад дээрх ажлын мэдээлэл байхгүй, мөн маягт 4-ийн дагуу хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээ хэсэгт дээрх ажлын мэдээллийг ирүүлээгүй нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.2-т “Оролцогч, түүний түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл: “Шаардана”. Оролцогч нь өөрийн болон түншлэлийн гишүүдийн хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 4-ын дагуу ирүүлнэ.” гэж заасан шаардлагыг хангасан гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

Иймд захиалагчийн тус тендер шалгаруулалтад холбогдуулан 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн 1/1951 тоот албан бичгээр гаргасан шийдвэрийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтын дагуу хүчингүй болгож байна.


9766015546

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтад үндэслэн тендер шалгаруулалтын тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг хуульд нийцүүлэн дахин хийхийг мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Вира сервис" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ